

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2015 ОНЫ
06 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Баянхонгор


Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл

Тус цагдаагийн газар нь 2015 оны 06 дугаар сар

- Энэ хугацаанд нийт 2605 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 206 нэгжээр буюу 8.5 хувиар өссөн.
- 565 буюу 21.6 хувийг гэмт хэргийн шинжтэй,
- 1975 буюу 75.8 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл
- Үлдэгдэл 47 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй 565 гомдол, мэдээллийн 214 буюу 37,8 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 351 буюу 62.1 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлж шалгасан байна.

Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 287 буюу 50,8 хувийг хуулийн анхны хугацаанд, 277 буюу 49 хувийг 5-19 хоногийн хугацаанд, захиргааны зөрчлийн шинжтэй 1975 гомдол, мэдээллийн 1953 буюу 99 хувийг 14 хоногт, 16 буюу 0,8 хувийг 15-28 хоногт тус тус шийдвэрлэсэн.



Захиргааны зөрчлийн 1975 гомдол, мэдээллийн:

- 1109 буюу 56,1 хувийг торгуулийн хуудсаар,
- 497 буюу 25,1 хувийг шийтгэврээр торгох,
- 163 буюу 8,2 хувийг баривчлах,


- 183 буюу 9,2 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан.

Хоёр. Гэмт хэргийн байдал


1. Аймгийн хэмжээнд 2015 оны эхний хагас жилд 190 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59 нэгжээр буюу 23,7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 107 буюу 56,3 хувь нь Баянхонгор суманд, 83 буюу 43,6 хувь нь бусад суманд гарсан.


Баянхонгор сумын багуудад гарсан гэмт хэрэг



Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал




Баянхонгор аймаг нь гэмт хэргийн гаралтаараа хил залгаа аймгуудтай харьцуулж үзвэл Архангай, Өвөрхангай аймгуудаас 29-31 хувиар бага, Говь-Алтай, Завхан аймгуудаас 43-63 хувиар их байгаа нь доорхи тоон үзүүлэлтээс харагдаж байна.



2. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:


- Хөнгөн ангилалын гэмт хэрэг 89 бүртгэгдэж -17 нэгжээр буюу 16 хувиар буурсан,
- Хүндэвтэр ангилалын гэмт хэрэг 88 бүртгэгдэж -34 нэгжээр буюу -27,8 хувиар буурсан,
- Хүнд ангилалын гэмт хэрэг 10 бүртгэгдэж -5 нэгжээр буюу -33,3 хувиар буурсан,
- Онц хүнд ангилалын гэмт хэрэг 3 бүртгэгдэж -3 нэгжээр буюу 50 хувиар буурсан.



3. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг:

44 хэрэг бүртгэгдэснээс 25 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон. Одоо бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй бусдын эд хөрөнгийг хулгайлах 17 гэмт хэрэг байна. Үүнээс 5 нь мал хулгайлах, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах 1, бусдын эд хөрөнгө булаах 1 гэмт хэрэг байна.

4. Гэмт хэргийн илрүүлэлт:



- Нийт хэргийн илрүүлэлт 56,8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12,2 пунктээр буурсан байна.
- Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 65 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10 пунктээр буурсан,
- Хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 52,2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12,5 пунктээр буурсан,
- Хүнд, онц хүнд эзэнгүй хэрэг бүртгэгдээгүй.

5. Бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл:


Нийт хэрэг	2014 оны 06-р сар	2015 оны 06-р сар	Харьцуулалт	
			Тоо	Хувь
Хүн амь	3	1	-2	-67%
Золгүй учрал	3	0	-3	-100%
ББМБГУ	76	69	-7	-9,2%
Хүчиндэх	7	3	-4	-57,1%
Бусдын эд хөрөнгө хулгайлах /үүнээс/	71	73	2	2,8%
Малын хулгай	16	25	9	56,2%
Иргэдийн өмчийн хулгай	51	42	-9	-17,9%
Тээврийн хэрэгслийн хулгай	1	6	5	5 дахин
Булаалт	1	1		
Дээрэм	2	2		
Залилан	4	2	-2	-50%
Танхай	12	2	-10	-83,3%
ТХХАБАЖЭГэмт хэрэг	24	13	-9	-45,8%
Бусад	46	24	-22	-52%

Бүртгэгдсэн бусад 24 гэмт хэргийг ангилан үзвэл: Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчсөн 1, алдуул мал гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших 3, хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших 2, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах 1, орчиндоо аюул учруулж болох амьтныг /нохой/ хамгаалалтгүй байлгах 6, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 11 байна.

6. Бүлэглэн үйлдсэн хэрэг 33 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгжээр буюу 5,7 хувиар,

- эмэгтэй хүн оролцсон хэрэг 22 бүртгэгдэж -19 нэгжээр буюу -46,3 хувиар буурсан,

- хүүхэд оролцсон хэрэг 18 бүртгэгдэж -9 нэгжээр буюу -33,3 хувиар буурсан,
- согтуугаар үйлдэгдсэн хэрэг 53 бүртгэгдэж -31 нэгжээр буюу -36,9 хувиар буурсан
- гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 37 хэрэг бүртгэгдэж 8 нэгжээр буюу -17,7 хувиар буурсан байна.




7. Гэмт хэрэгт 213 хүн холбогдон шалгагдсан:

- 14-17 насны 18, - төрийн албан хаагч – 13,
- 18-с дээш насны 195, - оюутан сурагч – 11,
- Эмэгтэй 22, - ажилгүй – 77,
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч – 25 -урьд ял шийтгэгдсэн–3 бүртгэгдсэн.
- Малчин -84

8. Гэмт хэргийн улмаас 196 иргэн хохирсон: 8 хүн нас барж, 90 хүн гэмтсэн байна.

- 283,7 сая төгрөгийн хохирол учирснаас 164 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 57,8 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлэлт /сая төгрөг/



Гурав. Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт

Аймгийн хэмжээнд 2015 оны 6 сард 7525 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь: өнгөрсөн оны мөн үеэс 672 нэгжээр буюу 9,8 хувиар өссөн.

- 269 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47 нэгжээр буюу -14,8 хувиар буурсан,
- 373 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 0,8 хувиар буурсан,
- 5784 зөрчлийг торгуулийн хуудсаар 26327,5 мянган төгрөгөөр,
- 1468 зөрчлийг шийтгэврээр 34067,8 мянган төгрөгөөр торгосон.
- 1256 хүн саатуулж, 4826,4 мянган төгрөгийн хураамж төлүүлж ажилласан.

ДҮГНЭЛТ

2015 оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд нийт 190 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59 нэгжээр буюу 23,7 хувиар буурсан. Тус аймаг нь гэмт хэргийн гаралтын бууралтаараа улсын хэмжээнд нэгдүгээрт бүртгэгдсэн байгаа нь сайшаалтай байна. Хэргийн илрүүлэлт 56,8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12,2 пунктээр буурсан. Хэргийн гаралт 9 суманд буурч, 5 суманд өсөж, 5 суманд ижил түвшинд байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 2 нэгжээр буюу 67 хувь, золгүй учрал 3 нэгжээр буюу 100 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 7 нэгжээр буюу 9,2 хувь, хүчин 4 нэгжээр буюу 57,1 залилан 2 нэгжээр буюу 50 хувь, танхай 10 нэгжээр буюу 83,3 хувь, Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 9 нэгжээр буюу 45,8 хувь, бусад гэмт хэрэг 22 нэгжээр буюу 52 хувиар, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 9 нэгжээр буюу 33,30 хувиар буурсан байна.

Харин өмчийн хулгайн гэмт хэрэг 2 нэгжээр буюу 2,8 хувь, малын хулгай 9 нэгжээр буюу 56,2 хувиар тус тус өссөн байна. Нийт бүртгэгдсэн 190 гэмт хэргийн 34 буюу 17,9 хувь нь “Баасан” гарагт, 29 буюу 15,5 хувь нь “Мягмар”, “Бямба” гарагт тус тус үйлдэгдсэн, 65 буюу 34,2 хувь нь 14-19 цагт, 60 буюу 31,5 хувь нь 22-06 цагуудад тус тус үйлдэгдсэн. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 44 бүртгэгдэж 15 нэгжээр буюу 51,7 хувиар өссөн

Илрүүлсэн зөрчил 672 нэгжээр буюу 9,8 хувиар өссөн.

САНАЛ

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ялангуяа өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор түншлэлийн багийг эрчимтэй ажиллуулж, бодлогын шинжтэй зохион байгуулалтын арга хэмжээ авах.

-Гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх чиглэлээр дорвитой ажил зохион байгуулж, гэмт хэрэгтэй тэмцэх шууд чиг үүрэг бүхий алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж тэдний хамтын ажиллагааг идэвхижүүлэх.

-Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.

-Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянхонгор сумын багуудын “Хөршийн холбоо”-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх.

-Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдсэн зөрчлийг илрүүлж, гэмт хэргийг бууруулах зорилгоор өдөр, орой, шөнийн хэв журмын эргүүл, хөдөлгөөнт эргүүлийн чиглэл, маршрут, хүн, хүчийг эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**